



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 133

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 56,000,000.00 (тавин зургаан сая) төгрөгийн балансын үнэ, 6,455,555.74 (зургаан сая дөрвөн зуун тавин таван мянга таван зуун тавин таван төгрөг далан дөрвөн) мөнгөний хуримтлагдсан элэгдэл бүхий цагдаагийн кабон Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд давхар бүртгэлтэй байгаа тул Өлзийт сумын ЗДТГ-ын бүртгэлээс хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Цагдаагийн газрын дарга О.Амарсанаа болон Өлзийт сумын ЗДТГ-ын дарга Б.Хорлоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СУХБААТАР

0100017